

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/126/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 70432545 цахим хаяг: ErdenetsetsegD@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
БСУГ	<i>Боловсрол, Соёл, Урлагийн газар</i>
НДШ	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>
ХАОАТ	<i>Хүн амын орлогын албан татвар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
СТСХ	<i>Санхүү, Төрийн сангийн хэлтэс</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

1.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА М.ПҮРЭВХҮҮ ТАНАА

2021.08.05 № 469
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,779,948.24</u>	<u>27,585,756.44</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	27,717,446.24	23,149,866.57
351	Түүхий эд материал	12,213,392.75	12,891,013.17
35110	Тусгай зориулалттай материал	12,213,392.75	12,891,013.17
354	Хангамжийн материал	15,504,053.49	10,258,853.40
35420	Аж ахуйн материал	8,979,863.40	3,396,163.40
35470	Бусад хангамжийн материал	4,513,690.00	6,862,690.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	4,435,889.87
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	00.00	4,435,889.87
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>264,055,669.36</u>	<u>281,308,634.62</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	264,055,669.36	281,308,634.62
392	Биет хөрөнгө	228,385,044.36	245,949,259.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	193,996,634.00	193,996,634.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,747,973.96	-17,495,947.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,500,000.00	72,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-54,125,000.00	-37,391,666.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,010,261.09	231,264,223.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-204,285,026.04	-212,084,976.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,690,840.61	27,690,840.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,426,872.29	-23,402,028.36
39217	Ном	10,772,180.95	10,772,180.95
393	Биет бус хөрөнгө	35,670,625.00	35,359,375.00
39301	Программ хангамж	2,125,000.00	2,125,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,554,375.00	-1,865,625.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,100,000.00	35,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>291,835,617.60</u>	<u>308,894,391.06</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>291,835,617.60</u>	<u>308,894,391.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	291,835,617.60	308,894,391.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,988,494.00	258,988,494.00
51101	Өмч: - төрийн	258,988,494.00	258,988,494.00
512	Хуримтлагдсан үр дүн	26,015,433.31	43,850,005.77
51210	Өмнөх үеийн үр дүн	26,015,433.31	26,791,232.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	17,058,773.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,831,690.29	6,055,891.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>291,835,617.60</u>	<u>308,894,391.06</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,814,356,751.11	2,357,845,398.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,936,738.00	132,638,198.77
120	Нийтлэг татварын бус орлого	1,936,738.00	132,638,198.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,573,000.00	132,638,198.77
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,573,000.00	132,638,198.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,812,420,013.11	2,225,207,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,157,695,876.00	2,133,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,157,695,876.00	2,133,301,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	654,724,137.11	91,906,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,307,000.00	25,201,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	614,417,137.11	54,015,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	12,689,440.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,829,435,816.53	2,338,321,019.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,829,435,816.53	2,338,321,019.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	977,595,440.53	521,994,619.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,499,073.00	250,917,172.27
210101	Үндсэн цалин	229,136,073.00	176,989,663.00
210102	Нэмэгдэл	132,363,000.00	50,594,663.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,876,000.00
210104	Урамшуулал	00.00	18,456,845.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,581,823.20	31,176,429.00
210201	Тэтгэврийн даатгал	19,560,907.00	21,393,629.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,287,165.20	2,445,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,829,731.00	1,956,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	445,820.00	489,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,458,200.00	4,891,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,690,561.00	18,286,065.00
210301	Гэрэл, цахилгаан	1,799,128.00	1,772,668.00
210302	Түлш, халаалт	12,017,829.00	14,511,805.00
210303	Цэвэр, бохир ус	1,873,604.00	2,001,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,121,284.63	90,167,256.72
210401	Бичиг хэрэг	59,000.00	400,300.00
210402	Тээвэр, шатахуун	9,969,272.03	3,058,900.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	677,294.00	517,535.73
210404	Ном, хэвлэл	180,000.00	222,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	311,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,235,718.60	451,900.00

210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	85,205,120.90
2107	Томилолт, зочны зардал	15,809,000.00	260,000.00
210702	Дотоод албан томилолт	15,809,000.00	260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,974,250.00	53,738,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,974,250.00	52,516,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	494,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	202,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	444,259,856.70	77,449,136.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	181,120.00	278,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	425,828,349.00	54,569,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,250,387.70	22,600,996.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,851,840,376.00	1,816,326,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,851,840,376.00	1,780,759,325.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	869,537,745.00	787,265,217.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	981,277,631.00	993,084,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,025,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	35,567,075.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	35,567,075.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-15,079,065.42	19,524,379.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,546,934.77	2,465,605.58
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,546,934.77	2,465,605.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,546,934.77	-2,465,605.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-18,626,000.19	17,058,773.46

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,812,420,013.11	2,225,207,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,812,420,013.11	2,225,207,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,157,695,876.00	2,133,301,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,157,695,876.00	2,133,301,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	654,724,137.11	91,906,100.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,307,000.00	25,201,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	614,417,137.11	54,015,160.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	12,689,440.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,812,420,013.11	2,225,207,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,812,420,013.11	2,225,207,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	958,604,637.11	408,880,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,571,100.00	249,005,299.27
210101	Үндсэн цалин	170,795,800.00	175,077,790.00
210102	Нэмэгдэл	165,671,700.00	50,594,663.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,163,600.00	4,876,000.00
210104	Урамшуулал	20,940,000.00	18,456,845.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,150,900.00	33,016,800.00
210201	Тэтгэврийн даатгал	19,249,300.00	23,234,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,225,400.00	2,445,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,780,300.00	1,956,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	445,100.00	489,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,450,800.00	4,891,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,141,500.00	18,286,065.00
210301	Гэрэл, цахилгаан	1,957,067.00	1,772,668.00
210302	Түлш, халаалт	12,310,829.00	14,511,805.00
210303	Цэвэр, бохир ус	1,873,604.00	2,001,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,680,000.00	4,962,135.73
210401	Бичиг хэрэг	228,183.00	400,300.00
210402	Тээвэр, шатахуун	4,065,803.00	3,058,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	790,294.00	517,535.73
210404	Ном, хэвлэл	00.00	222,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	311,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,720.00	451,900.00
2107	Томилолт, зочны зардал	15,800,000.00	260,000.00
210702	Дотоод албан томилолт	15,800,000.00	260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,133,611.11	53,738,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,133,611.11	52,516,060.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	494,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	202,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	435,127,526.00	49,611,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	278,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	434,627,526.00	49,333,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,853,815,376.00	1,816,326,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,853,815,376.00	1,780,759,325.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	869,537,745.00	787,265,217.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	983,277,631.00	993,084,108.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	35,567,075.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	35,567,075.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	6,831,690.29	26,015,433.31	291,835,617.60
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	258,988,494.00	6,831,690.29	26,015,433.31	291,835,617.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	775,799.00	775,799.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,988,494.00	6,831,690.29	26,791,232.31	292,611,416.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-775,799.00	00.00	-775,799.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,058,773.46	17,058,773.46
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	6,055,891.29	43,850,005.77	308,894,391.06

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,133,301,100.00	2,097,734,025.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,133,301,100.00	2,097,734,025.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,421,200.00	316,974,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,048,000.00	249,005,299.27
210101	Үндсэн цалин	183,339,200.00	175,077,790.00
210102	Нэмэгдэл	44,605,200.00	50,594,663.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,163,600.00	4,876,000.00
210104	Урамшуулал	16,940,000.00	18,456,845.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,016,800.00	33,016,800.00
210201	Тэтгэврийн даатгал	23,234,000.00	23,234,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,445,700.00	2,445,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,600.00	1,956,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,100.00	489,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,891,400.00	4,891,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,403,800.00	18,286,065.00
210301	Гэрэл, цахилгаан	1,526,200.00	1,772,668.00
210302	Түлш, халаалт	14,649,000.00	14,511,805.00

210303	Цэвэр, бохир ус	2,228,600.00	2,001,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,183,000.00	4,962,135.73
210401	Бичиг хэрэг	400,300.00	400,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,169,000.00	3,058,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	568,600.00	517,535.73
210404	Ном, хэвлэл	222,400.00	222,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	370,800.00	311,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	451,900.00	451,900.00
2107	Томилолт, зочны зардал	260,000.00	260,000.00
210702	Дотоод албан томилолт	260,000.00	260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,310,900.00	2,310,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,088,400.00	1,088,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	494,000.00	494,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,500.00	202,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	176,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9198700.00	9133500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	278,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,919,900.00	8,854,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1815879900.00	1780759325.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,815,879,900.00	1,780,759,325.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	820,685,700.00	787,265,217.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	994,784,200.00	993,084,108.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,133,301,100.00	2,097,734,025.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,133,301,100.00	2,097,734,025.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,133,301,100.00	2,097,734,025.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	590,301,082.06	91,906,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,301,082.06	91,906,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,301,082.06	91,906,100.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,847,100.00	
210101	Үндсэн цалин		
210102	Нэмэгдэл	182,847,100.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		
210402	Тээвэр, шатахуун	11,342,944.00	
2107	Томилолт, зочны зардал	6400000.00	
210702	Дотоод албан томилолт	6,400,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160384017.00	51,427,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,384,017.00	51,427,660.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229327021.06	40478440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	229,327,021.06	40,478,440.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18699900.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	18,699,900.00	
223001	Бусад хөрөнгө	18,699,900.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	609000982.06	91906100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	609,000,982.06	91,906,100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	63,064,347.06	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,424,068.00	25,201,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	461,512,567.00	54,015,160.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		12,689,440.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга М.Пүрэвхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт, шилэн данс, үндсэн хөрөнгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 01-наас 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хүний хөгжлийн эрэлт хэрэгцээг хангах арга зүй, технологийг санаачлагч, бүтээгч, түгээгч байгууллага, боловсрол, соёлын чанартай үйлчилгээг бий болгох, хөгжих чадвартай мэргэшсэн мэргэжилтэн бүхий орон нутгийн хөгжлийг загварчлагч сургалт, судалгааны төв байна гэсэн зорилт тавьсан жил болгон зарласан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;*
- ✓ *Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох;*
- ✓ *Багш, суралцагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;*
- ✓ *Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх;*
- ✓ *Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;*
- ✓ *Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;*
- ✓ *Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;*
- ✓ *Төрийн бус өмчийн боловсрол, сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх.*
- ✓ *Аймаг, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загварыг батлах.*
- ✓ *Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Боловсрол, Соёл, Урлагийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг БСШУ-ны яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт,

холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор БСШУЯ-ны дотоод хяналтыг 2020 онд тус байгууллагад хэрэгжүүлээгүй ч аймгийн Төрийн сангаас өдөр тутмын санхүүгийн гүйлгээнд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан мэдээ байхгүй байна.

Боловсрол, Соёл, Урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 2870025.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 28700.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 2340786.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 23407.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12622.8 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	62.5	0.0	-62.5
БАРАА МАТЕРИАЛ	27,717.40	27,585.80	-131.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	264,055.7	281,308.6	17,252.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	291,835.6	308,894.4	17,058.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	291,835.6	308,894.4	17,058.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	291,835.6	308,894.4	17,058.8

Авлага дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 62.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны хувь хүнээс авах авлага тайлант онд хоорондын тооцоогоор бүрэн барагдуулсан байна.

Тайлант онд хувь хүн, аж ахуйн нэгжтэй холбоотой тооцооны авлага үүсээгүй, бараа материалын хоорондын дотоод орлогыг бүрэн тооцож авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27585.7 мянган төгрөг болж 131.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тусгай зориулалтын материал зарлагдсантай холбоотой бараа материал буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 291835.6 мянган төгрөг, оны эцэст 304458.4 мянган төгрөг болж 12622.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БШУЯамнаас 39853.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан, 2019 оны 12 сарын 18-ны 127 тоот ИТХ-ын тогтоолоор 21500.0 мянган хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулж дуудлага худалдааны орлогыг аймгийн өмчийн санд бүрэн төвлөрүүлсэн байна.

Өр төлбөр оны эхэнд байхгүй тайлант онд үүссэн төлбөр тооцоог бүрэн барагдуулан ажиллаж оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 258988.5 мянган төгрөг болж тайлант онд нэмэгдээгүй байна.

Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 456511.3 мянган төгрөгөөр буюу 60.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 456511.3 мянган төгрөгийн орлогоос 24394.7 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатны захирагчаас төсөвт тусгагддаг нэмэлт орлогын санхүүжилт 432116.6 мянган төгрөгөөр орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 491114.8 мянган төгрөгөөр буюу 68.6 хувиар буурсан, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин 132363.0 мянган төгрөгөөр, буюу 37.1% хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 358751.8 мянган төгрөгөөр буюу 36.8% хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 775.8 мянган төгрөг бичигдсэн нь дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 330298.1 мянган төгрөг, тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг 1853915.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 2184213.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

БШУЯамнаас үндсэн үйл ажиллагааны зардалд 317421.2 мянган төгрөгөөр, тэтгэвэр тэтгэмжийн зардал 1815879.9 мянган төгрөгөөр нийт 2133301.1 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2133301.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 2133301.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2133301.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2097734.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2097734.0 мянган төгрөг буюу 95% зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөр арга хэмжээний хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	446.5
80802	Тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж	35,120.6
ДҮН		35,567.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас бөхийн тухай ном худалдаж авах, багш нарын баяр тэмдэглэх зардалд 25201.5 мянган төгрөг, БСШУЯ, болон төсөл хөтөлбөрөөс сургалт хийх 15276.9 мянган төгрөг, Хүүхэд харах үйлчилгээний зардалд 51427.6 мянган төгрөг нийт 91906.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос ном хэвлэлийн зардалд 11000.0 мянган төгрөг, багш нарын баярын зардалд 14201.5 мянган төгрөг, багш нарын бүсийн сургалтын зардал 15276.9 мянган төгрөг, аймгийн төв болон хилийн заставын хүүхэд харах үйлчилгээний зардалд 51427.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 100 мэдээллээс хугацаандаа оруулсан 76 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулснаас тэтгэвэр тэтгэмж олгосон 24 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Боловсрол, Соёл, Урлагийн газар нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	132,363.8	1	132,363.8	-	-	100
Зөвлөмж	3	108,953.6	2	21,790.7	1	87,162.9	20
Нийт дүн	4	241,317.4	3	154,154.5	1	87,162.9	85

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар 163988.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 140.0 мянган төгрөгийн 1 акт, 86636.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 77212.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар тайлант хугацаанд санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 140.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож 86636.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ.

1. Мөнгөн хөрөнгө

- 1.1. **Илрүүлэлт:** Өмнөх онд шатахууны тайланг үнэн зөв гаргах, анхан шатны баримт засварласан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн болов хэрэгжүүлж ажиллаагүй байна
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төлбөрийн акт тогтоох
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2. Үндсэн хөрөнгө

- 2.1. **Илрүүлэлт:** Өмнөх оны тайлангаар өгөгдсөн БСШУ-ны яамнаас болон бусад хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгийн тооцоо нийлж баталгаажуулах гэж өгөгдсөн хөрөнгийн орлогыг баримтаар баталгаажуулах зөвлөмж хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг хөрөнгө орлого аваагүй, шууд зардалд бүртгэсэн, болон хилийн заставуудад хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг зарим хүмүүсийн тусгай зөвшөөрөл байхгүй, үйл ажиллагаа эрхэлсэн хугацааны анхан шатны баримт дутуу байхад санхүүжилт олгосон, хүүхдийн тоо баталгаажуагүй, батлагдсан төсвийг нэр зөрүүтэй шилжүүлсэн зэрэг өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
- 2.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Албан шаардлага өгөх
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Аудитын зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар болосвролын салбарт олгогдож байгаа тэтгэвэр, тэтгэмжийн олголт, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3. Үндсэн хөрөнгө

- 3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа дахин ашиглах боломжтой тэг үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж ашиглах хугацааг сунгаагүй байна.
- 3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, хуулийн хэрэгжилт хангагдаагүй, дотоод хяналтын үр дүнг хэрэгжүүлээгүй байх
- 3.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллах
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4. Мөнгөн хөрөнгө

- 4.1. Илрүүлэлт: Боловсролын тухай хуулийн 43-т зааснаар тэтгэмжийг судалгаан дээр үндэслэн батлагдсан төсвийг байгууллагаар дамжуулан олгоогүй зарим хүнд олгосон тэтгэмж зөрүүтэй, зарим багш нарын ажилласан жил тодорхой бус байна.
- 4.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх
- 4.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Боловсролын тухай хуулийн 43-р зүйлийн 43.1.7-д "дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"
- 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр: Аудитын нэр:	Боловсрол, Соёл, Урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/126/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсрол, Соёл, Урлагийн газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх онд шатахууны тайланг үнэн зөв гаргах, анхан шатны баримт засварласан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн болов хэрэгжүүлж ажиллаагүй байна	140.0	Төлбөрийн акт	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, Нягтлан бодогч, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн	М.Пүрэвхүү Б.Уугантуяа Д.Нямдорж
2	Өмнөх оны тайлангаар өгөгдсөн БШУ -ны яамнаас болон бусад хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгийн тооцоо нийлж баталгаажуулах гэж өгөгдсөн хөрөнгийн орлогыг баримтаар баталгаажуулах зөвлөмж хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг хөрөнгө орлого аваагүй, шууд зардалд бүртгэсэн, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	86636.5	Албан шаардлага		
3	Боловсролын тухай хуулийн 43-т зааснаар тэтгэмжийг судалгаан дээр үндэслэн батлагдсан төсвийг байгууллагаар дамжуулан олгоогүй зарим хүнд олгосон тэтгэмж зөрүүтэй, зарим багш нарын ажилласан жил тодорхой бус байна.	77212.3	Зөвлөмж өгөх		
4	Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа дахин ашиглах боломжтой тэг үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж ашиглах хугацааг сунгаагүй байна.	0	Зөвлөмж өгөх		
ДҮН		163988.8			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

